



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 2,178,948.69 (хоёр сая нэг зуун далан найман мянга есөн зуун дөчин найман төгрөг жаран есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга Д.Дэлгэрсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001667

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн
 115... дугаар тогтоолын хавсралт



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА ХЭЛТСИЙН ҮНДСЭН
 ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо ширхэг	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1. Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс							
1	Програм (такс, санхүүгийн)	2008.01.01	715,000.00	1	715,000.00	715,000.00	-
	Дүн				715,000.00	715,000.00	-
2. Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс							
2	Програм (хангамж 2)	2013.08.27	748,948.69	1	748,948.69	748,948.69	-
	Дүн				748,948.69	748,948.69	-
3. Ховд аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс							
3	Програм (такс, санхүүгийн)	2008.01.01	715,000.00	1	715,000.00	715,000.00	-
	Дүн				715,000.00	715,000.00	-
	Нийт дүн				2,178,948.69 (хоёр сая нэг зуун далан найман мянга есөн зуун дөчин найман төгрөг жаран есөн мөнгө)	2,178,948.69 (хоёр сая нэг зуун далан найман мянга есөн зуун дөчин найман төгрөг жаран есөн мөнгө)	-